



ЭРҮҮЛ МЭНД

НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

2024 1-9с	Халдварт өвчин	3831
	Цочмог халдварт өвчин	3140
2025 1-9с	Халдварт өвчин	9060
	Цочмог халдварт өвчин	8212

2025 оны эхний 9 сарын байдлаар нийт халдварт өвчний 92%-г цочмог халдварт өвчин, 5%-г БЗДХ, 3%-г сүрьеэ өвчин тус тус эзэлж байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН -

10000 хүн
амд 204.1



2025 оны эхний 9 сарын байдлаар зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвар 10000 хүн амд 11.1 промилль байна.

ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН -

10000 хүн
амд 187.5



ХҮН АМ

2025 оны эхний 9 сарын байдлаар Баянзүрх дүүрэгт 4536 хүүхэд шинээр мэндэлж, төрөлтийн түвшин 10.1 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5-аар буурсан байна.



Төрөлт

Төрөлтийн
түвшин - 10.1

Нас баралт

Нас баралтын
түвшин - 2.8

Цэвэр өсөлт - 7.3

2025 оны эхний 9 сарын байдлаар нас баралт 1254 бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17-оор (1.3%) буурсан байна.

Жирэмсний эрт хяналтын хувь 90.9% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5-аар буурсан байна.

№	Эрт илрүүлгийн үзлэг	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь
1	Артерийн гипертензи /18+/ г/	270819	146872	54.2%
2	Чихрийн шижин хэв шинж -2 /35+/ г/	172708	113933	65.9%
3	Элэг /40+/ г/	131007	36618	28.0%
3	Хөхний хавдрын үзлэг /30-60нас/ г/	93378	61922	66.3%
4	Умайн хүзүүний эрт илрүүлэг /30+ 3,3 насаар/	32875	7764	23.6%



ТӨРСӨН ХҮҮХЭД

2024
1-9с



4977

2025
1-9с

4536

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 9 сарын байдлаар 4485 эх амаржин, 4536 хүүхэд шинээр мэндэлж, амьгүй төрөлтийн 16 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 3.5 промилль байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор буюу 3.5 промилоор буурсан байна. Эхийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдсэн бол Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 70 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 тохиолдлоор (3.2 промилль) нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

13.2 0-1 хүртэлх насны

1-5 хүртэлх насны 2.2

44.1 Эхийн эндэгдэл

ЭХИЙН ТӨРӨЛТ

0.2 Гэрийн төрөлт

Хяналтгүй төрөлт 0.5

Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 437-оор буюу 8.9 хувиар буурчээ. 2025 оны эхний 9 сарын байдлаар Гэрийн төрөлт 10 тохиолдол бүртгэгдэж нийт төрөлтийн 0.2 хувийг эзэлж байгаа бол хяналтгүй төрөлтийн 22 тохиолдол бүртгэгджээ.